



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 1128

Жаргалант

Бруцеллэз өвчнөөс урьдчилан  
сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Мал, амьтны Эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.7, 9.9, 23 дугаар зүйлийн 23.4, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны “Бруцеллэзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/166 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/329 тоот захирамж, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын “Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/19 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Бямбадалай (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Нарийн бичгийн дарга: Х.Дэмбэрэл (Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч)

Гишүүд

Н.Алтанбагана (Бумбат 1 дүгээр багийн Засаг дарга)  
М.Батжаргал (Моностой 2 дугаар багийн Засаг дарга)  
Д.Төрбат (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)  
Г.Тунгалагтуул (Буянт таван эрдэнэ” ХХК)  
Ж.Баттулга (Жавхлант ачит тулга БХБГН)  
Б.Батцэнгэл (Сорлог мал ХХК)  
Э.Мөнх-Амгалан (Мөнхсүрэг-Эрдэнэ ХХК)

2. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.

3. Сумын хэмжээнд адуунаас бусад мал сүргийн охин төлийг бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад бүрэн хамруулах ажлыг 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 20 хоногийн дотор шуурхай, чанартай зохион байгуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Х.Дэмбэрэл)-д үүрэг болгосугай.

5.Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг батлагдсан хуваарийн дагуу технологит хугацаанд шуурхай зохион байгуулах, уг арга хэмжээний ач холбогдол, Бруцеллэз өвчний хор уршгийн талаар ухуулга, суртчилгаа хийх ажлыг багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нарт даалгасугай.

6.Дээрх арга хэмжээг мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж, мал эмнэлгийн цахим системд төлөвлөгөөг бүрэн оруулж, үр дүн гүйцэтгэлд хяналт тавьж, дархлаажуулалтын явцын мэдээг 7 хоног бүр сумын Засаг дарга, аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж ажиллах, уг арга хэмжээний дараа санхүүжилтийн материалд хяналт тавьж баталгаажуулах, цахим системд гүйцэтгэл тулгаж баталгаажуулах ажлыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Х.Дэмбэрэл)-д даалгасугай.

7.Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлсхийсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцохыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Бямбадалай )-д үүрэг болгосугай.

8.Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Нямсүрэн)-д даалгасугай.



Ц.ДАРХАНБААТАР